



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 2 сарын 21 өдөр

Дугаар А/9

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэдээлэл, технологийн үндэсний парк" төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшилд буй төрийн өөрийн өмчид оруулсан хөрөнгө оруулалт, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой асуудлыг судлан санал гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч:

Ц.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга.

Гишүүд:

Д.Нарангэрэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга;

Л.Нямдорж Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга;

В.Дарханбаатар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага төлөөллийн албаны дарга;

Д.Батболд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн;

Ө.Саранцэцэг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн;

Р.Ширчинням Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн;


132013871

О.Мөнхзаяа Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн салбарын эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн;
Ж.Золзаяа “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ-ын Захирал;
Б.Лхагвасүрэн “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ-ын Инноваци, технологи судалгаа хөгжүүлэлтийн хэлтсийн дарга;
Нарийн бичгийн дарга:
А.Молор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн.

2.Ажлын хэсгийн баримталж ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.


3.Удирдамжид заасан асуудлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан судлан, саналаа танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын
2024 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
1/9 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

НЭГ. Ажлын хамрах хүрээ

1.1. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшилд буй төрийн өөрийн өмчид оруулсан хөрөнгө оруулалт, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой асуудлыг судлан, санал гаргах;

1.2. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газар болон “Нью тур сафарис” хязгаарлагдмал хариуцлагатай компаниас ирүүлсэн саналыг судлан, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах;

1.3. Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшилд буй төрийн өөрийн өмчийг түрээслүүлэх гэрээний хэрэгжилтийг судлан, дүгнэлт өгөх;

1.4. Хөрөнгө оруулалт болон түрээсийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлаар судлах.

ХОЁР. Дүгнэлт

2.1. Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу ажиллаж, санал гаргана.

2.2. Дүгнэлтийг 2024 оны 01 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагад танилцуулна.

-----oO-----